



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2014 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А-86

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Усны тухай хуулийн 7.2 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журмыг"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журамд заасан үзүүлэлтийн дагуу анхдагч мэдээллийг Улсын усны мэдээллийн санд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар /Т.Булган/, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Гантулга/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Гантулга/, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Усны сав газрын захиргаад, Цаг уур, орчны шинжилгээний газар, Байгаль орчны мэдээллийн төвд даалгаж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Төрбаяр/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Байгаль орчны сайдын "Журам батлах тухай" 2006 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 180 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  С. ОЮУН